



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 19 өдөр

Дугаар А/493

Мандалговь

Ашигт малтмал тээвэрлэлтийн
чиглэл батлах тухай

Авто замын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4, Автотээврийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 09 тоот тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Говь-Угтаал сумын нутагт орших MV-010665 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Хараатын төмрийн уурхайгаас Говьсүмбэр аймаг хүртэлх 64 км ашигт малтмал тээвэрлэлтийн автозамын чиглэлийг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан чиглэлийн дагуух орон нутгийн чанартай авто замыг арчилж хамгаалан, замын тэмдэглэгээ байрлуулж, маршрутын дагуу тээвэрлэлт явуулж байхыг "Шанжин-Орд" ХХК-ийн захирал (Н.Цогзолмаа) -д үүрэг болгосугай.

3. Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын хүрээнд батлагдсан маршрутын дагуу тээвэрлэлт явуулж буй эсэхэд хяналт тавьж ажиллахыг холбогдох сумдын Засаг дарга, аймгийн Авто тээврийн төв (Ц.Хүрэлбаатар), Цагдаагийн газар (Б.Мөнхбат), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), Байгаль орчин аялал жуулчлалын газрын дарга (Н.Гантулга) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

431210611